

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дарьсүрэн	Дугаар	L165
Оршин суугаа аймаг	Сэлэнгэ аймаг	Оршин суугаа сум	Алтанбулаг
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хярааны дуган	Сүм хийдийн дугаар	СЭАБ 018
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 21	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Хярааны дуган

Асуулт:-**Караны** голын ойролцоо байсан хийд хэд орчим ламтай байсан юм бол?

Хариулт:-**Караны** ойролцоо Буган суурь гэж байгаа, одоо суурь нь бий. Их олон лам байсан. Одоо дээр нь төмөр гүүр барьчихсан.Цаана нь бол Согтуугийн гудамж гэдэг нэртэй дандаа буриад айл байдаг байсан.

Асуулт:-**Ироны** тосгон гээд байна шүү дээ. Оросын тосгон байна тийм ээ?

Хариулт:-Одоо тийм юм байхгүй шүү дээ. Юу ч байхгүй. Тэнд чинь Оросын **деревен** гэж байсан юм. Оросын шарил байсан одоо ч бүр устаад **дуусч** байх шиг **байнаа**. Айл хунар буугаад.

Асуулт:-Хэр зайтай юм,тэр дуганы суурь нь.

Хариулт:-Дуганы суурь нь ингэж яваад айлуудынхаа дунд. Тэгээд дуган суурийн чинь сүлжээтэй үс гэж байсан юм. Хойно нэг нуур байгаа. Нуур нь ширгээд юу ч байхгүй болсон. Тэр тахиж байсан уул энэ байж байна. Бор булан гэдэг байсан.